

16**20-Р ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН
ХЭРЭГЛЭЭ****Б.Нарантуяа.****Оршил**

Зах зээлийн нийгэмд шилжээд багагүй хугацаа өнгөрөөгөөд байгаа ч манай улсын хувьд энэхүү тогтолцоо нь цоо шинэ зүйл байсан билээ. Хэдий тийм боловч энэхүү зах зээлийн сэтгэлгээ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо бүрэлдэхээс өмнө монголчуудын амьдралын хэв маягт нэгэнт бүрэлдсэн байжээ.

20-р зууны эхэн үеийн монголчуудын хэрэглээ нь зах зээлээ хэрхэн нөхцөлдүүлж байсан хийгээд энэ нь тухайн ард түмний уламжлалт сэтгэлгээнд хэрхэн тусгалаа олсоныг судлах нь чухал ач холбогдолтой гэж үзлээ.

**Нэг. 19-р зууны сүүлч, 20-р зууны эхэн үеийн монголчуудын
амьдралын хэв маяг**

Монголд 18-р зууны эхэн үеэс Хятадын, 19-р зууны дунд үеэс Оросын худалдааны сорон мөлжигч капитал нэвтэрч зарим мэдээгээр 500 орчим пүүс дэлгүүрээс салбарласан жижиг худалдааны цэг, дохиур, дамнуурын худалдааны хэлбэрээр газар бүхэнд тархаж 15000 хүнийг ажиллуулж Монголчуудыг 30 сая лан мөнгөний өрөнд оруулжээ. [1]

Оросын эрдэмтэн И.М.Майскийн “Хувьсгалын өмнөх Монгол орны хүн амын жилийн дундаж хэрэглээ 67,5 сая алтан рубль, үүнээс 43,5 сая нь мах, сүү, ноос, арьс шир гэх мэтийг өрх бүр өөрийн аж ахуйгаас хангаж байсан натурал хэрэглээ, 20 сая нь гаднаас худалдаж авсан бүтээгдэхүүн, үлдэх 4 сая алтан рубль нь зээлээр авсан барааны зориулагдаж байжээ.” гэж багцаалан тооцжээ.

1880 оны үед Позднеевийн тодорхойлсноор хүрээнд өөрсдөө үйлдвэрлээд өөрсдөө худалдаг нарийн боовны үйлдвэр 5, лааны үйлдвэр 2,

зэс гуулин сав, бурхан цутган хийх газар 20, шавар цаасаар бурхан барих ба зурах газар 40 орчим, элдүүрийн газар 12 байжээ [3].

Хүрээний харчууд эмээлийн мод засах, хийх, монгол малгай хийх, лам нарын гутал хувцас оёх, мөнгөний дарх хийх гар урлалын ажил эрхлэгчид нэлээд бий болжээ. Зүүн хүрээний сангийн үйл оёх бойвчин, малгайчин, титэмчин эмэгтэйчүүд Богдын том лам нарын гутал хувцас, малгайг хийхийн зэрэгцээгээр хатгамал наамал бурхан хийдэг байжээ. Бас Хөлийн мөдчин, Сонгины хавьд бургасаар араг, шээзгийг хийж хүрээ хөдөөд худалдах хүмүүс нэлээд байжээ. Хүрээний монгол эмээлчдийн хийсэн эмээл хүрээ хөдөөд их гүйлгээтэй зүйлийн нэг байв [3].

Хоёр. Ардын Харилцаан Туслалцах Хоршооны үүсэл хөгжил [2]

Монгол орон 19-20-р зууны заагт капиталист орнуудын зах зээлийн хүрээнд гүнзгий татагдан оржээ. Таваар мөнгөний харилцаа улам хүчээ авч феодалын нийгмийн уламжлалт эдлэхүүний хувшия аргацаасан аж ахуйд хүчтэй нөлөөлжээ. Үүнтэй уялдаж Монголын хотууд, төвлөрсөн зах зээлийн төвүүд болон хувирах зүгт хандаж байжээ.

Ардын Засгийн Газар анхны хуралдаануудаараа ард олны эрх чөлөөг хүндэтгэн хуучин эзэрхэг засгийн үеийн хууль дүрмүүдийг цуцлан гадаадын худалдаачдад төлөх зээлийн өрийг хүчингүй болгожээ.

Ардын Засгийн Газрын Сангийн яам 1921 оны 10-р сарын 1-ний өдөр MAXTX-ны 53 зүйлтэй дурмийг төлөвлөн зохиож батлан олон аймаг хошуу, шавийн отог багууд, хязгаар нутгийн харуул гэх мэт засаг захиргааны бага нэгжүүдэд хүртэл тараасан байна.

1921 оны 11-р сарын 2-нд Богд хаанд Ардын Засгийн Газрын Сангийн Яам эрхлэн тусгай айлтгах нугалбар бичгийг өргөж MAXTX байгуулах, анхны даргаар Чагдаржавыг томилж түүнд Жүн ван зэрэг шагнан явуулахыг хүссэн соёрхол зарлиг хайрлахыг хүсчээ. Богд хаан “Зарлиг мэдэв” хэмээн улаан бийрээр баталсан байна. [4] 1921 оны 11-р сарын 15-наас MAXTX-ны анхны гишүүдийг элсүүлэн 12-р сарын 15-ны өдөр гэхэд нийт 116 хүн, 6173 лан мөнгө буюу мөнгөн янчаанд шилжүүлснээр 8800 төгрөгийн хөрөнгийг хуримтлуулжээ. [5]

Богд хаан Эх дагинын хамт 700 шахам лан мөнгөөр хувь нийлүүлж MAXTX-нд элссэн нь сүсэгтэн олон ардад сайны дууриаллыг үзүүлсэн хэрэг болсон байна. Мөн төв орон нутагт шашин төрийн нөлөө ихтэй хүмүүс оржээ.

MAXTX-нд ЗОУ-ын Төв Хоршоо Центроюзаас 4300 лан мөнгө үндсэн хөрөнгө болгон тусалж байжээ.

1921 оны 12-р сард MAXT Хоршооны хэлтэс Сангийн Яамны харьцанд ажиллаж тус хоршоог олон нийтийн сайн дурын хоршоолсон хэлбэрийн байгууллага болгож Засгийн Газраас олгосон хашаа байшинг 1000 гаруй лан мөнгөөр засварлуулж, контор, агуулах, дэлгүүрийг нээж, Алтанбулаг хотоос тээвэрлэж ирсэн даалимба 3760 зах, цай, гурил, гутал зэрэг 22971 лан мөнгөний барааг хүлээн авч хүрээний барааны захын ойр анхны дэлгүүрийг

нээж, бараа таваар худалдаж, түүхий эд, ангийн үс зэргийг бэлтгэж эхэлжээ. [6]

Энэ дэлгүүрт цагаан гурил жинг 10-15 мөнгө, жийсүүн даавууг толгойгоор 28 янчаан, орос шар будаа пүүг 4 янчаан, орос хатуу чихэр пүүг 18 янчаан, модон хайрцагтай орос ёотон (25 боодолтой)-г 12 янчаан гэх мэтээр худалдаж байв. [7]

1921 оны 12-р сарын 9-12-ны өдрүүдэд 30 тэмээ хөсөгтэй 2 гол жингийн цуваа гарган цай 150 хунз, даалиба 470 зах, дүнсэн тамхи 28 авдрыг илгээж, уг хөсөг 1922 оны эхээр Хатгал харуулын газар хүрч 186 ард 935 лан мөнгөөр хувь нийлж арилжаа худалдааны хэргийг үүсгэн ангийн үс худалдан авч эхэлжээ. [8]

Гурав. 1930-1950 оны үеийн монголчуудын хэрэглээний онцлог

1920-1960 онд нүүдлийн МАА эрхэлсэн хувийн аж ахуйтай монголын мал 30-40 сая байв. Коммуны үед монголын МАА нэрвэгдсэн. Сумын хоршоо 2 гэртэй, нэг гэр нь контор, нөгөө нь маш бага бараатай дэлгүүр байжээ. Малчдын зайлшгүй хэрэгцээний ногоон цай, дүнсэн тамхи, лаа, ямбуу, жигүүн, сатин, даалимба, торго (үзэгдэх төдий), чудэнз, гурил, шар будаа, ёотон зэрэг 10 гаруй нэрийн бараа байв. 1935-36 он хүртэл хятад цай ууж байв. 1937 онд урд хил хаагдсанаар энэ барааг аймаг сумаар нь тоолж байгаад Оросоос гэрээ хийж Цагааннуур, Хатгал, Цагаан-Эрэг, Эрээнцавын дамжлага баазуудаар дамжуулан авч эхэлжээ.

Монголын авдаг шар будааны дийлэнх нь Хэнтий, Дорнотоор буудаг байв. Тэр үед шар будаа нь иргэдийн гол хэрэгцээ нь байв. Гурил одоогийн шиг ийм элбэг биш.

Жилд нэг л удаа дамжлага баазуудаар бараа ирдэг. Барааны захиалга ба гэрээ нь тус тусдаа бараа гүйлгээний мэдээгээр гардаг байжээ. 1950-иад он хүртэл ийм байдалтай байв. Гэхдээ дайны жилүүдэд дээрх бараа нь бүр ховорддээжээ.

MAXT Хоршоо бараагаа борлуулна. Айлуудаас арьс шир, өлөн гэдэс, ангийн үс цуглуулдаг. Зуны цагт хонины ноосыг хяргаж аваад боож тушаадаг байлаа. Харин 1950-иад оноос тааран шуудайд хийдэг болжээ. 1940 он хүртэл ямааны ноолуур, бодын хөөвөр, адууны дэл сүүлийг авч ашиглаж мэддэггүй байжээ. Ингээд 1940 оноос эхлэн дээрх зүйлсийг албан журмаар айл өрхүүдэд оногдуулах болсон байна.

Эсгий нь ард иргэдийн гол хэрэгцээ байсан учир 1935-36 онд эсгийлэх, ноос цэмбэний фабрик байгуулагдсан. 50-иад онд комбинат бор эсгий хий болсон. 1939 он хүртэл хүн, мал эмнэлэг нь уламжлалт арга ажиллагаатай байсныг сум бүрээс нэг хүн авчирч 6 сарын сувилагчийн курс хийсэн. Эндээс гарсан сувилагч нь сумынхаа бүх эмнэлэгийн ажлыг хийдэг байв. Эмнэлгийн хэрэглээнд цагаан даавуу энэ үеэс нэвтрэч эхэлсэн байна.

1930-д онд бага сургууль бий болсноор хэд хэдэн шинэ бараа нэмэгдсэн. Үүнд галстукийн (пионерийн улаан бүч) улаан даавуу, бэх, үзэг, гутал,

дэвтэр, харандаа, малгай зэрэг болно. Эдгээр нь монгол хүний гараар үйлдвэрлэгдээгүй, Зөвлөлт Орос Улсаас ирдэг байжээ.

Харин орон нутагт багш нар очсоноор 1938-40 онд шинэ хэрэглээг хангах зорилгоор артель бий болсон. 1950-д оноос иргэд тав тухтай, цэвэрхэн орчныг эрхэмлэх болсноор монгол гэр модон хаалгатай болж, зуух яндан хэрэглэж эхэлжээ.

1958 онд нэгдэлжих хөдөлгөөн ялж, ноос, мах, сүү, цөцгийн тос, ааруул зэргийг албан журмаар авдаг байснаа зогсоосон билээ.

Дүгнэлт

1. 20-р зууны эхэн үед монголчууд Хятад, Оросын наймаачдаас өөр зах зээлгүй, ялангуяа хятад худалдаачдад мөлжигдөн, хэдэн үеэр тэдний хүүлсэн мөнгөний өрөнд ороод байсан нь улс орны эдийн засгийг сүйрэхэд хүргэж, Дундад иргэн улс ба Орос улс хуваан залгихад бэлэн байдлыг үүсгэжээ.

2. Монголын дэвшилтэт үзэлтэй сэхээтнүүд улс орноо хөгжүүлэх гол үндэс нь улс орон өөрийн мөнгөн санхүү, худалдааны төвтэй болох явдал гэдгийг олж харан MAXTHоршоог байгуулсан нь унаж доройтсон эдийн засгаа сэргээх, хоцрогдсон мал аж ахуйн бодит сэтгэлгээнээс ангижрах сайхан эхлэл болжээ.

3. Монгол хүний амьдралд эмнэлэг, сургууль зэрэг соёл, шинжлэх ухааны эхлэл тавигдсанаар тэдний хэрэгцээ эрс шинэчлэгдэж, суурин амьдралын хэв маягт орж эхэлжээ.

Ашигласан ном хэвлэл

1. Харилцан туслалцах хоршооны сонин. №2 1924 он
2. Чо. Банзрагч. Монголын эд хэрэглэгчдийн хоршооны үүсэл хөгжил. докторын зэрэг горилох диссертаци
3. Л.Дүгэrsурэн. Улаанбаатар хотын түүхээс. УБ 1956 он. 39-40; 43-44-р тал
4. YTTA. ФА-1 Д-1, х/н т/з; Ф-17 Д-1, х/н 19; А.З.Ф-173. Д-1, х/н-22
5. Ч.Банзрагч, Т.Дашдэлэг. Монголын хоршоолол. УБ ,1996 он 172-176-р тал
6. Ардын үндэсний эрх сонин. №97 (325) 1935-12-16
7. ХБЯ-ны архив Ф-17 Д-1 х/н-109

Төв кооперативын хорооны төлөөлөгчдийн 8-р их хуралд илтгэх илтгэл. УБ , 1930 он 8-р тал